МОНЦАМЭ 1921

# Ерөнхий сайд У.Хүрэлсүхийг “Монгол цэргийн нэгдсэн холбоо”-ны тэргүүнээр сонгов

МОНГОЛЫН МЭДЭЭ | УЛС ТӨР




**Улаанбаатар /МОНЦАМЭ/.** “Монгол цэргийн нэгдсэн холбоо” төрийн бус байгууллага өнөөдөр анхдугаар хуралдаанаа хийлээ. Тус байгууллага Монгол Улсын ирээдүй болсон залуу үед эх оронч үзлийг төлөвшүүлэх, Монгол улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлын дархлаа, үнэт зүйлсийг хамгаалах, төр, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилготой аж.

Монгол Улсад цагдаа, хил хамгаалах, зэвсэгт хүчний 27 төрийн бус байгууллага байдаг бөгөөд эдгээр холбооны нийгэмд хүрэх дуу хоолойг нэгтгэх, байр суурийг бэхжүүлэх зорилгоор уг нэгдсэн холбоог байгуулжээ. Анхдугаар хуралдаанд дээрх төрийн бус байгууллагын 950 төлөөлөгч оролцож, тус холбооны тэргүүнийг сонгож, бүтэц, үйл ажиллагааны дүрмийг батлав.

Baramsai Chadraabal-Ð½ Ð·Ñ Ñ Ð°Ð³.

Холбооны тэргүүнээр Ерөнхий сайд У.Хүрэлсүхийг 100 хувийн саналаар сонголоо. Мөн холбооны тэргүүн, удирдах зөвлөлийн 31 гишүүнтэй байх бөгөөд төв салбар Улаанбаатарт байрлах, орон нутагт салбар нэгжтэй байж болохоор дүрэмд тусгав. Холбооны ээлжит их хурлыг зургаан жилд нэг удаа, ээлжит бус чуулганы холбооны тэргүүний шийдвэрээр хуралдуулж байх юм.

# Монгол цэргийн нэгдсэн холбооны тэргүүнээр У.Хүрэлсүх сонгогдлоо

ХУВААЛЦАХЖИРГЭХ

N

NEWS.MN

- НИЙГЭМ
  - МЭДЭЭ

2019-04-04




"Монгол цэргийн нэгдсэн холбоо" төрийн бус байгууллага өнөөдөр /2019.04.04/ анхдугаар хуралдаанаа Төрийн ордонд хийлээ. Тус төрийн бус байгууллага нь эх оронч үндэсний үзэл, бахархлыг хөгжүүлэн, ард түмнээ соён гэгээрүүлж, Монгол улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлын оюуны дархлаа, үнэт зүйлсийг хамгаалан бэхжүүлэх үйлсэд төр, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран зүтгэх зорилготой бөгөөд 1000 гаруй гишүүнтэй аж.

Монголын цэрэг, хүчний байгууллагын нийт 27 төрийн бус байгууллага байдаг бөгөөд эдгээр холбоодыг нэгтгэж нийгэмд дуу хоолойгоо нэгтгэх, үндэсний аюулгүй байдлын эрх ашигт нийцүүлэх хэрэгжүүлсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, байр суурийг бэхжүүлэн нийгэмд үйлчилдэг төрийн болон төрийн бус байгууллагуудтай нягт хамтран ажиллах гэнэ. Мөн Монгол улсын төрийн цэргийн байгууллагуудын цэргийн жинхэнэ албан хаагчид, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын ажилтан, албан хаагчид, түрүүч, байлдагчид болон иргэдийн сайн дурын үүсгэл санаачлагын байгууллага аж. Холбоо нь их хурал, бага хурал, удирдах зөвлөл тэргүүнээс бүрдэх бөгөөд төв салбар Улаанбаатарт байх бөгөөд орон нутагт салбар нэгжтэй байж болохыг дүрэмд тусгажээ. Мөн холбооны ээлжит их хурлыг зургаан жилд нэг удаа, ээлжит бус чуулганыг холбооны тэргүүний шийдвэрээр хуралдуулж болох дүрэмтэй. Тус холбоог шүүхийн шийдвэр болон гишүүдийн олонхын саналаар татан буулгах боломжтой гэнэ.

Түүнээс гадна холбоо нь гишүүдийн татвар, иргэд, аж ахуй нэгж, дэмжигч байгууллагын хандив тусламж дэмжлэг, дүрмийн зорилоо хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааны орлого, гадаадын хандив, тусламж, дэмжлэг, холбооны гишүүдийн татварыг Удирдах зөвлөлийн хурлаар жил бүр ялгавартай тогтоох зэргийг дүрэмдээ тусгаж өгчээ.

Ийнхүү анхдугаар хуралдаанаар холбооны дүрэм, бүтцийг баталж, Бага хурлын гишүүд болон тэргүүнээ сонгосон юм. Анхдугаар хуралдаанд нийт 950 төлөөлөгч оролцож байгаа бөгөөд хуралдаан даргалагчийн зүгээс холбооны тэргүүнд Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийг нэр дэвшүүлсэн бөгөөд 100 хувийн саналаар томилов.